

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Огноо: 2017 оны 4 сарын 23-ны өдөр

Цаг: 10:15 -14:00

Байршил: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Махатма Гандигийн гудамж, Корпорейт Хотел энд Конвеншн Центрийн хурлын танхим

Хурлын дарга: Чулууны Ганхуяг

Хурлын нарийн бичгийн дарга: Жаргалсайханы Золзаяа

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: 73

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: 11,075,612 ширхэг.

Хурлын ирц: 79.55% буюу бүрэн.

Тусгай тэмдэглэл:

Хурлын дарга Ч.Ганхуяг: Төлөөлөн Удирдах зөвлөлөөс хурлын даргыг томилсон ба гүйцэтгэх удирдлага хурлыг даргалж байгаа тухай; Хурлын материалыг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 244 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын журмын дагуу 2017 оны 03 сарын 16-ны Өдрийн дотор брокер, дилерийн компаниудад хүргүүлж хувьцаа эзэмшигчдийн хурлын матриалтай танилцах боломжоор хангаж ажилласан талаар танилцуулж, хэлэлцэх асуудлыг 100% дэмжин хурал эхлэв.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

- 1 дэх асуудал:** Ард Санхүүгийн Нэгдэл ХК-йн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- 2 дахь асуудал:** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дуусаж байгаатай холбогдуулж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох;
- 3 дахь асуудал:** Ард Санхүүгийн Нэгдэл ХК-йн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай.

1 дэх асуудал:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь: Хурлын дарга Ч.Ганхуяг

Танилцуулгын гол агуулга: Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2016 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх мэдээллийг танилцуулав.

Танилцуулсан нь №2: Ард Даатгад ХХК-ийн Гүйцэтгэх захирал А.Батболд

Танилцуулга гол агуулга: Ард Даатгал ХХК-ийн 2016 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.

Танилцуулсан нь №3: Ард Кредит ББСБ-ын Гүйцэтгэх захирал Ч.Ганзориг

Танилцуулга гол агуулга: Ард Кредит ББСБ-ын 2016 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.

Танилцуулсан нь №4: Ард Секюритиз ҮЦК ХХК-ийн Гүйцэтгэх захирал А.Идэрбат

Танилцуулга гол агуулга: Ард Секюритиз ҮЦК ХХК-ийн 2016 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.

Танилцуулсан нь №5: Монгол Шуудан ХК-ийн Дэд захирал Г.Тэлмэн

Танилцуулга гол агуулга: Монгол Шуудан ХК-ийн 2016 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.

Тусгай тэмдэглэл:

1. Хувьцаа эзэмшигч Б.Төрболд: Аудитаар шалгуулсан тайлан материалтай танилцахын тулд бидэнд санхүүгийн мэдлэгээ сайжруулах хэрэг гарч байна.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Бид хувьцаа эзэмшигчидтэйгээ жилийн турш байнгын холбоотой байхыг хичээдэг. Мөн хагас сайн өдөр бүр иргэдийн санхүүгийн боловсрол олгох сургалтуудыг хийдэг.

2. Иргэн Болор: Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааг авахаар сонирхож байгаа учир хуралд ирлээ. Ашиг өмнөх оныхоос огцом өссөн нь юутай холбоотой вэ? Ил тодын хуультай холбоотой байсан уу? Хувьцааны тоо ширхэг мөн нэмэгдэх үү, хэвээрээ байх уу?

Хурлын дарга Ч.Ганхуяг: 3,4 тэрбум төгрөг нь цэвэр 2016 оны үйл ажиллагааны ашиг байсан. Жишээ нь, бид бага үнээр ТТДС-ийн хувьцааг авч байсан бол 2016 ондоо үнэд оруулан зарсан. Зарласан хувьцаа буюу 22 сая ширхэг хувьцаа байдаг. Энэ тоондоо багтааж ТУЗ нь хувьцаа нэмж гаргаж болдог байгаа. Сая болсон ТУЗ-ийн хурлын үеэр бид энэ асуудлыг ярих байсан боловч ярьж чадаагүй дууссан байгаа. Халаасны хувьцааг бол бид арилжаанд оруулах боломжтой байдаг.

2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2016 үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.

3. Энэ асуудлаар санал хураасан дүн:

Зөвшөөрсөн				Татгалзсан				Түдгэлзсэн			
Нийт саналын эрхтэй хувьцаа 13,922,518		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 11,075,612		Нийт саналын эрхтэй хувьцаа 13,922,518		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 11,075,612		Нийт саналын эрхтэй хувьцаа 13,922,518		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 11,075,612	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
13,922,518	100%	11,041,038	99.69%	13,922,518	100%	-	0%	13,922,518	100%	-	0%

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.69% нь зөвшөөрсөн.

2 дахь асуудал:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь: Хурлын дарга Ч.Ганхуяг

Танилцуулгын гол агуулга: Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн мэдээллийг танилцуулав.

Танилцуулсан нь №2: Тооллогын комиссын дарга Намуугэрэл

Танилцуулгын гол агуулга: Кумулятив аргаар ердийн болон хараат бус гишүүнийг сонгох зааварчилгааг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Тусгай тэмдэглэл:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Г.Цогбадрах тодорхой шалтгааны улмаас нэрээ татаж буйгаа мэдэгдэв.

2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр:

1. “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:
 1. Жанчив овогтой Оюунгэрэл
 2. Чулуун овогтой Ганхуяг
 3. Рашле овогтой Бруно
 4. Хоброу овогтой Антони
 5. Цогбадрах овогтой Ариунтөгс
 6. Хишигдорж овогтой Батхишиг
 7. Чинбат овогтой Номин
2. “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүдээр

1. Пүрэвжаргал овогтой Батбаяр
2. Одончимэд овогтой Одбаяр
3. Лхагвасүрэн овогтой Соронзонболд
4. Нармандах овогтой Мөнхнасан нарыг тус тус томилсугай.

3. Энэ асуудлаар санал хураасан дүн:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:

Овог нэр	Санал өгсөн эрх
Ж.Оюунгэрэл	11,784,771
Ч.Ганхуяг	9,325,528
Х:Батхишиг	8,830,404
Бруно Рашле	8,805,582
Энтони Хоброу	8,879,922
Ц.Ариунтөгс	14,897,416
Ч.Номин	11,767,437

Үүнээс Ж.Оюунгэрэл, Ч.Ганхуяг, Х.Батхишиг, Бруно Рашле, Энтони Хоброу, Ц.Ариунтөгс, Ч.Номин нар сонгогдов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:

Овог нэр	Санал өгсөн эрх
П.Батбаяр	9,501,709
Л.Соронзонболд	9,858,847
Г.Цогбадрах	1,703,401
О.Одбаяр	9,647,719
Н.Мөнхнасан	8,236,990

Үүнээс, П.Батбаяр, Л.Соронзонболд, О.Одбаяр, Н.Мөнхнасан нар сонгогдов.

3 дахь асуудал:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан нь: Хурлын дарга Ч.Ганхуяг

Танилцуулгын гол агуулга: Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл

2. Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

3. Энэ асуудлаар санал хураасан дүн:



Зөвшөөрсөн				Татгалзсан				Түдгэлзсэн			
Нийт саналын эрхтэй хувьцаа 13,922,518		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 11,075,612		Нийт саналын эрхтэй хувьцаа 13,922,518		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 11,075,612		Нийт саналын эрхтэй хувьцаа 13,922,518		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 11,075,612	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
13,922,518	100%	11,060,718	99.87%	13,922,518	100%	-	0%	13,922,518	100%	-	0%

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.87% нь зөвшөөрсөн.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Хуралд оролцогсдод талархал илэрхийлснээр 14:00 цагт хурал өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга:

Танилцсан Хурлын дарга:

 Ж.ЗОЛЗАЯА
 Ч.ГАНХУЯГ